

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 32
1.	<i>“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	5 – 31
2.	<i>Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан</i>	31 – 32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 19-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 48 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Болормаа, Д.Ганбат, Х.Жангабыл, Н.Наранбаатар, Н.Номтойбаяр, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Б.Тулга, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Э.Бат-Амгалан, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэх асуудлын дараалалд орсон Эрчим хүчний сайдын мэдээллийг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Батлан хамгаалах яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Бум-Очир, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, Г.Очирбат, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх асуудлыг хойшлуулахаар тогтов. /15.00/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
13 цаг 48 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна.

Ирцийг танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Дуламын Бум-Очир, Батбаярын Жаргалан, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Ганбатын Г.Очирбат, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ганбатын Хосбаяр, Дамдины Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Лутаагийн Энхнасан, Дашцэрэнгийн Энхтүвшин, Сүхбаатарын С.Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдсэн байна.

Энэ гээд 2025 оны 11 сарын 19-ний өдөр хуралдааны эзнийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 3 асуудал байгаа.

Нэгдүгээрт, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл анхны хэлэлцүүлэг. Эдийн засгийн байнгын хороонд санал, дүгнэлтийг хүргүүлэх байгаа.

Хоёрдугаарт нь, Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

Гуравдугаарт, Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй хүлээлгэн хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох гэсэн ийм асуудлууд байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангаж гэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт гээд эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох асуудал дээр Эрчим хүчний сайд нь оролцох боломжгүй байна. Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар оролцуулъя гэсэн хүсэлтийг тавьсан юм.

Тэгээд би энэ дээр зарчмын асуудал. Бид цаг хугацаатай, эрчим хүчний аюулгүй байдалтай холбоотой асуудал учраас сайд нь оролцох зүйтэй гэсэн асуудлыг тавьсан байгаа. Сайд томилолттой гэсэн хүсэлтийг тавьсан юм байна.

Тэгэхээр энэ дээр хойшлуулах саналыг гаргаж байна. Гишүүд дэмжих үү? Сайдыг заавал ч үгүй байлгаж байгаад өвөлжилт болоод эрчим хүчний аюулгүй байдалтай холбоотой мэдээллээ сонсох нь зөв байх гэсэн саналтай байна. Тийм ээ.

Хэлэлцэх асуудлаас Эрчим хүчний сайдын мэдээллийг хойшлуулъя гэдгээр горимын санал гаргаж байна.

Горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Хэлэлцэх асуудлаас хасахыг гишүүд дэмжлээ. 66.7 хувиар. Баярлалаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,

анхны хэлэлцүүлэг,

Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуулттай холбогдуулаад оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Мөн Батлан хамгаалах яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга Чулуунбуйрын Гандирваа гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Хэд хэдэн Байнгын хороод давхцаад байгаа учраас ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүд хоёр, гурав хуваагдаад асуултад хариулаад явж байгаа юм байна.

Өчигдөр хуралдах байсан хурлууд өнөөдөр хойшлоод, төлөвлөгдөөгүй хурлууд хэлэлцэгдээд, үндсэн чиглэлээ давхар давхар хэлэлцээд яваад байгаа гэдгийг гишүүд ойлгож байгаа байх.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Г.Очирбат гишүүнээр тасалъя.

С.Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: 2010 онд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлагдаад 15 жил болж байгаа.

Яах вэ, ер нь сүүлийн үед шинэчлэх, өөрчлөх тухай яриа нэлээн явж байгаа. Яагаад гэхээр нөхцөл байдал аюулгүй байдлын ойлголт их өөрчлөгдөж байгаа.

Орос, Украины асуудлаас болоод дэлхий нийтийн өрсөлдөөнт зүй тогтол, хурцадмал байдлаас болоод аюулгүй байдлын уламжлалт ойлголт нэлээн шинэчлэгдэж байна.

Нөгөө талаасаа технологийн хурдтай өөрчлөлт нь аюулгүй байдалтай холбоотой асуудлыг цогцоор нь эргэж харах зайлшгүй шаардлагатай болж байна.

Тэгэхээр бид нэгэнт таван жилийн төлөвлөгөө ярьж байгаа учраас аюулгүй байдал хийгээд түүнийг хангах –

- эдийн засгийн орчин,
- хөрөнгө оруулалтын орчин,
- стратеги бодлого -

-дээр ч бид цогцоор нь авч үзэх зайлшгүй шаардлагатай байх. Жишээлбэл,

- ➔ 1941-1945 оны Дэлхийн II дайны 4 жилийн дотор шинжлэх ухаан 35 жилийн хурдаар хөгжсөн гэсэн дүгнэлт байдаг.
- ➔ 2020-2022 оны ковидын үед шинжлэх ухаан багадаа 8-аас 12 жилийн хурдаар хөгжиж байгаа.

Тэгэхээр сүүлийн үед хиймэл оюун ухаантай холбоотой асуудал ч маш хурдтайгаар өөрчлөгдөж байгаа. Тэр утгаараа таван жилийн төлөвлөгөөнд аюулгүй байдал, түүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт, эдийн засгийн орчин, хөгжлийг тодорхойлохдоо ер нь ямар ямар, яах вэ зарим нь би нууцын зэрэгтэй юмыг хариулахгүй байж болно.

Ер нь ямар концепц дээр түшиглэж байгаа юм бэ? Асуултаа илүү ойлгомжтой байлгахын үүднээс Эрчим хүчний сайдаас асуухаар Эрчим хүчний сайд ингэж хариулж байгаа байхгүй юу. Жишээлбэл,

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бид 2020 он гэхэд гэж байгаа юм.
- Шатахуунаа дотооддоо 100 хувь хангадаг болно.
- Эрчим хүчээ дотооддоо 100 хувь хангадаг болно –

-гэсэн зорилго бид 10 жилийн хугацаатай тавиад түүндээ хүрч чадаагүй 5 жил өнгөрсөн явж байгаа.

Үгүй ээ, тэгээд одоо ийм байна шүү дээ. Нэг бол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа өөрчлөх юм уу, эндээ яах юм бэ гэж асуухаар “Бид хөнжлийнхөө хэмжээнд хөлөө жийе” гэсэн хариулт өгөөд байгаа юм.

Тэгэхээр энэ зүй тогтол дээр бид ер нь яах юм бэ?

Бид яах вэ, тэгэхээр дараа жилийн хөгжлийн хөтөлбөр яриагүй, таван жилийн төлөвлөгөө ярьж байгаа. Тэр утгаараа энэ асуултад би нэг ойлголт авмаар байна. Хэрвээ хариулахад бэлэн биш байвал. Бэлэн биш байна уу? Тэгвэл энэ асуудлыг Та энэ ажлын хэсэг дээр болон энэ зүйл дээр үзээч ээ. Дараа дараагийн зүйл дээр үзээч ээ. Энэ аягүй нарийн зүйл байгаа юм шүү. Тийм.

Тэгээд холбогдох Хөгжлийн сайд нь өөрөө байж байгаад, мөн Батлан хамгаалахын сайд нь байж байгаад энэ асуудлыг хариулбал их зүгээр. Би Хэрэг эрхлэхийн сайдад энэ асуултад яг салбарын деталийн юм асууж байгаа учраас бэлтгэлээ хангаж байж хариулсан нь дээр байх гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Бараг санал хэллээ гэж ойлгоё. Анхаарах асуудлууд. Тэгье дээ. Тийм ээ.

Энэ асуудлууд дээр бэлтгээд эргээд гишүүдэд мэдээллүүд хүргэх асуудлуудыг анхаарах ёстой байна.

Дараагийн шатны хэлэлцүүлгийн чуулган дээр орно. Тэр дээр нягталж мэдээллүүдийг нэгтгэж хүргүүлэх шаардлага байна гэж үзэж байна.

Дараагийн гишүүн. Д.Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Өдрийн мэнд хүргэе.

Энэ үндсэн чиглэл дээр болоод тогтоолын төсөл дээр дээд боловсролын тухай асуудал маань жаахан хаягдаад байх шиг санагдаад байх юм.

Тогтоолын төслийн 37 дугаар хуудсанд 1.1.3.2 дээр “**дээд боловсрол**” дээр “хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй болон тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр төгсөгчдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ” гэсэн. Миний олж харснаар ганцхан заалт байгаад байна.

Тэгээд дээд боловсролын асуудлаа хэдүүлээ анхаарахгүй болохгүй байна. Энэ чинь хэдэн багш нарын нуруун дээр үлдсэн. Одоо ингээд 20, 30-аад жил боллоо шүү дээ.

Тэгээд бид дээд боловсрол эзэмшүүлэх, их дээд боловсрол эзэмшүүлэхийн тулд хүүхдүүдээ гадаадад яваад сурна л гэдэг ийм л байдалтай байгаа юм. Уг нь зарчмын хувьд бид мэргэжилтнээ улсдаа, эх орондоо бэлдэх ёстой л доо. Энэ системээ илүү хөгжүүлмээр, сайжруулмаар байна. Монголд байгаа их дээд сургуулиудыг дэлхийн жишигт хүргэмээр байна. Өнгөрсөн жил билүү Монгол Улсын Их Сургууль 1500 руу орж ирж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэлд ямар ажил хийх вэ? Нэгдүгээрт. Үүнийг үндсэн чиглэлээсээ ерөөсөө орхигдуулмааргүй байна. Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэлээс. Ингээд орхигдоод байх юм бол дээд боловсролын асуудал чинь бүр улам хэцүүдэх нь.

Ер нь манай ерөнхий боловсролын сургууль төгсөж байгаа хүүхдүүд төгсөөд Монголынхоо их дээд сургуулиудад ордог, өрсөлдөөд ордог, тэр нь нэр хүндтэй байдаг ийм л жишиг рүү бид очмоор байна. Тэгээд энэ дэндүү хол байна. Биднээс. Энэ рүү алхам алхмаар ойртмоор байна. Энэ чиглэлд юу хийх вэ? Нэгдүгээр зүйл.

Хоёрдугаар зүйл. Шинжлэх ухааны асуудал. Шинжлэх ухаан дээр бас бидний хүсэж мөрөөддөг заалтууд оржээ. Жишээ нь, дотоодын нийт бүтээгдэхүүнд судалгаа, хөгжлийн салбарын зардлын эзлэх хувь одоо 0.15 байгаа. Үүнийг бид зөндөө ярьсан. Манай Д.Рэгдэл гишүүн зөндөө ярьсан. Дотоодын нийт бүтээгдэхүүний 0.15 гэдэг маш бага. Дэлхийн жишиг юм уу, олон улсын жишиг рүү ойртуулъя, 2 хувьд хүргэе гэдэг юм байгаа.

Тэгээд энэ дээр сайн тал нь 2 хувьд хүргэнэ гээд оржээ. Тэгээд яг 2 хувьд хүргэхээр төсөв дээр ямар ачаалал ирэх юм? Заримдаа боломжтой, боломжгүй гэж ярьдаг. Төсөв хүнд байгаа энэ үед уг нь болговол сайн байна. Гэхдээ үнэхээр болгох нөөц бололцоо байгаа юм уу? Энэ чиглэлийн хэвлэж өгсөн 69 дүгээр талд байгаа шүү.

Баснэг зүйл байгаа. Яг энэ шинжлэх ухаантай холбоотой. “Олон улсын хянан магадлал бүхий мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог нэмэгдүүлэх” гэж байгаа юм.

Энэ дээр 985 гэдэг нь миний ойлгож байгаагаар одоо байгаа тоо байх. Одоо их дээд сургууль болоод Шинжлэх ухааны академи зэрэг эрдэм шинжилгээний байгууллагууд ажиллаж байгаа судлаачдын, олон улсын мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлүүдэд хэвлүүлэгдсэн тоо болов уу гэж бодож байна.

Үүнийг ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүн асуултаа гүйцээе.

Д.Бум-Очир: Энэ 1985-ыг 1405-д хүргэнэ гэж байгаа юм.

Тэгээд энэ дотор мань мэтийн шинжлэх ухааны салбарт ажилладаг хүмүүсийн хэвлүүлсэн өгүүллийн тоо ч гэсэн орж байгаа байх.

Тэгээд энэ эрдэмтэд, судлаачдыг яаж, юугаар дэмжиж хэвлэгдэж байгаа өгүүллийн тоог нь 985-аас 1405 болгох гэж байгаа юм бол оо? Энэ дээр бодитой төлөвлөсөн ажил юм юу байдаг юм бол, юу хийх гэж байгаа юм бол гэж судлаачид маань харж, хүлээж байгаа болов уу? Энэ хоёр асуулт дээр хариулт авах гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Эхлээд П.Наранбаяр сайд.

Дараагийн асуулт дээр бэлтгэж байгаарай.

П.Наранбаяр: Дээд боловсролын асуудлаар ярьж байна.

Ер нь Д.Бум-Очир гишүүнтэй санал нэг байна. Юу вэ гэхээр үнэхээрийн дотооддоо сураад, дотоодын сургалт нь өөрөө сайн, бүх хүн гадаад руу зорих нь одоо бол тийм өндөр шаардлагатай үе биш гэж харж байгаа.

Үүнтэй холбоотойгоор “Боловсролын зээлийн сан” дээр **“2+2”** хөтөлбөрийг тусгасан. 2 жил заавал Монголдоо сурсан байж гадаад явах ийм шаардлагыг тавьж эхэлж байгаа.

Түүний зэрэгцээ өнөөдөр МУИС 1500 дээр жагссан “Times Higher Education”¹-ээр. Түүнийгээ энэ жил дахиад хадгалсан байна лээ. Арай жоохон урагшлуулсан байна лээ. АУИС 1230 орчимд жагсаад ирж байгаа.

Тэгэхээр бид үндэснийхээ их дээд сургуулиудыг хоёр, гурван зүйлээр сайн дэмжих ёстой гэж харж байна.

► **Нэгдүгээрт**, тогтмол зардлыг нь жил болгон суулгаж, тогтмол өгч байх явдал.

Ингэх юм бол зөвхөн оюутны төлбөр дээр амьдардаг их дээд сургуулиуд биш, төрөөс бас санхүүжилтээ авч, суурь судалгаа руугаа боломжтой хэмжээгээр санхүүжилтээ хийдэг болох боломжтой.

► **Хоёрдугаарт**, Их дээд сургуулийн өөрсдийнх нь бие даасан байдлыг илүү сайн хангах ёстой.

¹ **Их Британи Улсад** төвтэй, дэлхийн дээд боловсролын салбарын мэдээлэл, дүн шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **хувийн байгууллага**.

Энэ чиглэлээрээ Удирдах зөвлөлөөр нь дамжиж бүх томилгоогоо хийж байна. Хууль нь тэгээд гарсан. Улс төрчдийн ямар нэгэн зохисгүй оролцоог хаах бодлогыг хуулийнхаа хүрээнд Боловсролын яам хэрэгжүүлж явж байгаа гэдгийг хэлье.

► **Гуравдугаарт нь**, их дээд сургуульд чадварлаг сайн профессоруудыг урьж ажиллахад дэмжлэг үзүүлье.

“Боловсролын зээлийн сан” энэ чиглэл рүү боломжийг нь ашигладаг больё гэсэн саналууд гарч байгааг дэмжиж байгаа.

Мөн тодорхой шинжлэх ухааны чиглэлийн зарим нэг хичээлүүдийг англи хэлээр шууд үзэх боломжийг хангах. Мэдээж сонголттойгоор. Ийм боломжийг бий болгох нь зүйтэй гэж харж байна.

Ингээд их дээд сургуулийн багш нарын олон улсад бүртгэлтэй сэтгүүлүүдэд өгүүлэл гаргахыг дэмжиж бид энэ “Доктор хамгаалах зөвлөл”-ийг улс орон даяар бүрдүүлж, тэндээсээ тухайн тухайн сургуулиуд өөрсдийнхөө чиглэлээр доктор хамгаалуулах зөвлөлөө сонгох боломжийг олгож эхэлсэн.

Тэгэхээр энэ нь юу гэсэн үг вэ гэхээр энэ дээр тавигдаж байгаа юм нь олон улсын сэтгүүл дээр өгүүллээ хэвлүүлсэн байх гол шаардлагыг тавьж эхэлж байгаа. 3 жилд нь сольж эхэлж байгаа. Хэрвээ тийм өгүүлэл гаргаагүй бол тэндээсээ хасагдах боломжтойгоор зохицуулж эхэлж байгаа. Ийм маягаар “Судалгааны их сургууль” болж хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх ёстой гэж харж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хоёр дахь асуулт. 5 номер дээр очоод асуултад хариулаарай. Албан тушаал, овог, нэрээ хэлээрэй.

Сая нэмэлтээр орж ирсэн хүмүүсийг Та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Булгаагийн Ганбат орж ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Пүрэвдоржийн Чандмань, мөн тус яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батжаргалын Төгөлдөр, тус яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батхишигийн Мөнх-Эрдэнэ гэсэн хүмүүс байна.

5 номер асуултад хариулъя.

Б.Ганбат: Сайн байцгаана уу? Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат байна.

Д.Бум-Очир гишүүний шинжлэх ухаантай холбоотой асуултад хариулъя.

Нэгдүгээрт, шинжлэх ухаан, технологийн салбарт өнөөдөр зарцуулж байгаа санхүүжилт, хөрөнгө оруулалт нийлээд 0.2 хувь хүрэхгүй байгаа. Үүнийг 2 хувьд хүргэнэ гэсэн байгаа.

Үүнийг ямар арга замаар хүргэх вэ гэхээр –

► **Нэгдүгээрт**, зөвхөн улсын төсвийнх биш –

- хувийн хэвшил,
- бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар,
- аймаг, орон нутаг,
- гадаадтай хамтарсан төслийн санхүүжилтийг энд бид оруулж байгаа.

Өнөөдөр бид үүнийгээ тооцож ерөөсөө чадахгүй байгаа. Хамтарсан судалгаа, их сургуулиуд, хүрээлэнгүүд дээр хэрэгжүүлж байгаа төслийн хувийн хэвшил болон гадаатай хамтарсан санхүүжилт, хөрөнгө оруулалтыг тооцож чадахгүй байгаа.

Үүнийгээ оруулаад тооцох юм бол өнөөдөр бидний үзэж байгаагаар 0.5-аас 0.7 хувьд байгаа.

Тэгэхээр үүнийг өсгөх бололцоо байна гэж харж байгаа.

► **Хоёрдугаарт**, эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиуд дээр хийгдэж байгаа судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, оюуны өмчийг ашиглах талаар ахиц гаргая гэж байгаа.

Маш их хэмжээний оюуны өмч, патентууд бүртгэгдсэн байна. Гэвч ашиглагдаж байгаа лицензийн гэрээгээр болон бусад хэлбэрээр ашиглаж байгаа нь маш хангалтгүй байгаа.

Тэгэхээр шинжлэх ухааны ажлын дараагийн шат буюу мэдлэгийг дамжуулах, ашиглах тал дээр тодорхой ажлууд хийнэ гэж үзэж байгаа. Энэ дээр ялангуяа судалгаа хөгжүүлэлтийн ажилд –

- оруулж байгаа хөрөнгө оруулалт,
- хамтарсан судалгааны санхүүжилт,
- оруулж ирсэн лабораторийн тоног төхөөрөмж,
- эм урвалжийг бид хөнгөлөх чөлөөлөх талаар зарим хуулиуд байна.

Инновацийн хуулийг дагалдаж гарсан 6 татвартай холбоотой хуулийн хэрэгжилт ерөөсөө байхгүй байгаа. Үүнийгээ амь оруулж хэрэгжүүлье гэж байгаа.

Өгүүлэл, Publications²-тай холбоотой тэр тоон дээр юу гэж үзсэн бэ гэхээр ерөнхийдөө Web of Science³ болон бусад Scopus⁴-ын бүртгэлтэй Impact Factor⁵ өндөртэй сэтгүүлүүдийг бид авч үзэж байгаа.

Манай үндэсний тийм чанартай “Impact Factor” өндөртэй сэтгүүлүүд цөөхөн байгаа. Үүнийг бий болгоно гэж үзэж байна.

Зэрэгцүүлээд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын –

- санхүүжилт, хөрөнгө оруулалт,
- лабораторийн нөхцөлийг сайжруулах ажил хийгдээд явж байгаа.

Нэгдсэн лабораторийн барилга дээр энэ жил 40 гаруй тэрбум төгрөг, өнгөрсөн 2 жилд 60 хэдэн тэрбум төгрөг тавигдсан байгаа.

Ингээд лабораторийн орчин, дэд бүтэц сайжраад ирэхээр судлаачдаасаа судалгааны ажлын чанартай үр дүнгүүд гарна гэж үзэж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүн асуултаа тодруулъя.

Д.Бум-Очир: П.Наранбаяр сайдаас тодруулах гэсэн юм.

Нэгэнтээ дээд боловсрол, их сургуулиудын тухай асуудал ярьж байгаа учраас.

Одоо Боловсролын ерөнхий хууль дээр Судалгааны их сургуулийн тухай хуулийг Засгийн газар оруулж ирнэ гэсэн заалт байгаа.

- Энэ хуулиа хэзээ оруулж ирэх вэ?
- Юу болж байгаа вэ?
- Энэ хууль ер нь ямархуу хууль орж ирэх юм?

Би өмнөх Засгийн газрын үед өргөн барьсан хуулийн төслийг нь үзсэн. Тэр агуулга нь төрийн өмчийн их сургуулиудыг нэгтгэх үзэл санаа явж байсан.

Хэрвээ одоо Та бодвол хуулийн төсөл оруулж ирэх болов уу гэж бодож байна. Хэзээ оруулж ирэх вэ? Нэгд.

Хоёрт, энэ нэгтгэх үзэл санаа үргэлжлээд байх уу, эсвэл үүнээсээ ухрах нь зүйтэй гэж үзэж байна уу? Энэ асуултад хариулаад өгөөрэй. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. П.Наранбаяр сайд.

² Албан ёсоор хэвлэгдэж нийтэд хүрсэн бүтээл.

³ Олон улсын эрдэм шинжилгээний өгөгдлийн сан.

⁴ Elsevier-ийн эрдэм шинжилгээний ишлэлийн сан.

⁵ Сэтгүүлийн нөлөөллийн үзүүлэлт.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр Судалгааны их сургуулийн тухай хуулийг Их Хурлаар хэлэлцүүлэх асуудал руу орсон байгаа. Энэ дээр хуулийн төслийг дахиж шинэчилж янзлах ажил нь явагдаж байгаа гэж ойлгож байгаа.

Ер нь цаашдаа их сургуулиудыг зөвхөн механикаар нийлүүлээд байх нь оновчтой арга хэмжээ биш байна гэдэг нь харагдаад байгаа. Амьдрал дээр ч гэсэн тийм. Төрийн өмчийн сургуулиуд хоорондоо өрсөлдөх хэрэгтэй. Нөгөө талдаа ижил мэргэжлээр ижил сургалтуудыг хэт их явуулах нь. Жишээлбэл, байгалийн ухаанаар илүү мэргэжиж явдаг их сургууль нийгмийн ухаанаар хэтэрхий их хүч хаяж, тэндээ элсэлтийг их авах юм бол сургалт өөрөө унаж эхэлдэг нь харагдаж байна. Тийм ээ.

Тэгэхээр ийм маягийн зүйлүүд байгаа учраас судалгааны их сургууль руу зорьсон хуулийн төслийг барихдаа олон нийтийн санал бодол, ялангуяа мэргэжлийнхний дуу хоолойг сайн сонсож, нийлүүлж ингэж оруулж ирэх ийм бодлого барина. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүн болсон уу? Л.Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Сайн байцгаана уу?

Өнөөдөр Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэлийг хэлэлцэж байна. Энд үндэсний өрсөлдөх чадварын нэг гадаад худалдааны асуудлыг ярих хэрэгтэй байх.

Тэгэхээр үндсэн чиглэлийн 9.1.1-д “худалдааны тариф, гадаад худалдааг хөнгөвчлөх” гээд үзүүлэлтийг нь 50.5, хүрэх үзүүлэлт, индекс нь энд байхгүй байна. Яагаад байхгүй байгаа юм бол?

Мөн Ази, Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцыг идэвхжүүлэх гээд “чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулна” гэж байна. Гурван хэлэлцээр байгуулахаар шинээр төлөвлөж байгаа юм байна. Энэ ямар ямар хэлэлцээрүүдийг байгуулах гэж байгаа юм бэ?

Хоёр дахь асуудал нь, “дипломат харилцааг өргөжүүлэх” гээд, “гадаад улсын виз авах нөхцөлийг хөнгөвчлөх” гэж байна.

- Энэ ямар улсуудын визийг хөнгөлөх гэж байгаа юм?
- Улсуудтай хэлэлцээр хийгээд визүүдийг нь чөлөөлөх гэж байгаа юм бэ?

Мөн өнгөрсөн таван жилийн тайланг хэлэлцэхэд Гадаад хэргийн яамтай холбоотой ганцхан заалт байсан байна. Энэ хэрэгжээгүй байна.

Токио дахь Элчин сайдын яамны барилгыг сайжруулна гээд.

- Энэ яагаад хэрэгжээгүй юм бэ?

Сангийн яамнаас асуух хэрэгтэй байх л даа. Санхүүжилт нь гараагүй юм шиг харагдаж байна.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя.

Эхний асуултад хэн хариулах вэ? Худалдааны тариф, бодлоготой холбоотой асуудлаар Эдийн засаг, хөгжлийн яам хариулах уу? Эдийн засаг, хөгжлийн яам. 6 номер.

Б.Мөнхсүх: Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх. Гишүүний асуултад хариулъя.

Таван жилийн үндсэн чиглэлийн төсөл маань бодлогын 8 чиглэлийн хүрээнд явж боловсруулагдсан. Үүний нэг гол хэсэг нь “Үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэсэн бодлогын хүрээ байгаа.

Энэ дундаа эдийн цэцгийн өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худал худалдаатай холбоотой олон үр дүнгүүдийг тодорхойлсон байгаа.

Энэ хүрээнд нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтарч ажилласан. Энэ хүрээнд гадаад худалдааны чиглэлээр ажилладаг төсвийн ерөнхийлөн захирагч нар болон холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж энэ үр дүнгүүдийг тодорхойлсон байгаа.

Г.Тэмүүлэн: Өөр нэмж хариулах. Элчин сайдын яамтай холбоотой асуудлаар мэдэж байгаа зүйл байна уу?

Ж.Дэлгэржаргал дарга уу? Тэгье. Хэдэн номер вэ?

Ж.Дэлгэржаргал: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ж.Дэлгэржаргал.

Токио дахь Элчин сайдын яамны байрыг худалдаж авах асуудал ер нь төсөв дээр байнга санал нь ирдэг.

▷ **Нэгдүгээрт,** төсвийн хязгаар, боломж.

▷ **Хоёрдугаарт,** одоо Элчин сайдын яамны байр байгаа боловч байр нь “шаардлага хангахгүй” гэдэг асуудал яригдаж байгаа.

2026 оны төсвийн төсөл дээр 116.0 тэрбумаар худалдаж авах санал ирсэн. Гадаад яам ярилцаад түрээсээр үү, эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг шийдэхээр явж байгаа. Төсөв дээр тусгагдаагүй байгаа.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Гадаад худалдааны асуудал орхигдоод байгаа.

Тэгэхээр Худалдааны тухай хууль уг нь өмнөх парламентаар санаачлагдаад явж байсан шүү дээ.

- Тэр хууль ямар шатандаа явж байгаа вэ?
- Тэр хуулийг сайжруулаад дахиж барихгүй юм уу?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Засгийн газраас Худалдааны хууль. 7 номер уу? 7 номер.

Б.Төгөлдөр: Гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яам. Б.Төгөлдөр.

Эдийн засаг, хөгжлийн яаман дээр экспортын бус бараа, бүтээгдэхүүний экспортыг дэмжих тийм хуулийн төслийг боловсруулаад явж байгаа. Саналуудыг холбогдох яамдаас аваад явж байгаа.

Мөн гадаад худалдааны чиглэлээр байгуулахаар ажиллаж байгаа 3 хэлэлцээр байгаа. Үүнд:

- ▷ **Нэгдүгээрт,** Евразийн эдийн засгийн холбоотой байгуулах худалдааны түр хэлэлцээр.
- ▷ **Хоёрдугаарт,** Бүгд Найрамдах Солонгос Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр явж байгаа. Одоо 5 дугаар раунд нь эхлэх гэж байгаа.
- ▷ **Гуравдугаарт,** Бүгд Найрамдах Хятад Ард Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр хийхээр судалгаа хийгдэж байгаа.

Г.Тэмүүлэн: Д.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би энэ таван жилийн үндсэн чиглэл дээр зарчмын хувьд эсрэг байр суурьтай байгаа юм.

Ер нь манай улсын хувьд урт хугацааны бодлого, төлөвлөлт гээд –

- урт хугацаа гэдэг нь 30 жил,
- дунд хугацаа гэхээр 10 жил, 5 жил, 4 жил гэсэн –

-ийм гурван бичиг баримт би гарах болоод байгаа юм.

Тэгэхээр дөрвөн жил буюу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь таван жилийн дунд хугацааны хөтөлбөртэйгөө хэтэрхий ойрхон, тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй маш адилхан төстэй.

Тэгээд энэ нь өөрөө засаг солигдохоор буцаад эрх барьж байгаа нам, одоо жишээлбэл сонгууль олонх болсон нам нь өөрийнхөө бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор таван жилийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг өөрчлөх магадлал өндөртэй бичиг баримт болоод байгаа юм.

Тэгэхээр зарчмын хувьд үүнийг больё гэсэн бодолтой байгаа юм. Гэхдээ Засгийн газрын хувьд хууль биелүүлж байгаа учраас асуудлаа оруулж ирж байна. Тэгэхдээ өөр нэг хуулиа Улсын Их Хурал хэлэлцэж амжаагүй байгаа юм.

2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлээ бид ерөөсөө яриагүй байгаа.

Тэгэхээр энэ асуудлаа ярьж байгаад болж байгаа, болохгүйг нь дүгнэж, тэгээд ирэх таван жилийн асуудлуудаа ярих юм уу гэдгийгээ шийдэх ёстой байх гэж бодож байна.

Ерөнхийдөө үндсэн чиглэлд орсон зүйлүүдийг нь харахаар буцаад л бид төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг шигээ, таван жилийн төлөвлөгөө гаргадаг шигээ бүгдийг нь л төр хийнэ, хүмүүсийн амьдралыг бид шийдэж өгнө гэсэн иймэрхүү л бодлогын юм гэхээр улсын төсвөөс мөнгө гаргасан, улс барина гэсэн, том том үйлдвэрүүд барина гэсэн, хүмүүсийн амьдралыг бид өөрсдөө шийдэж өгнө гэсэн иймэрхүү л амлалт яваад байна л даа.

Бид өнгөрсөн 30 гаруй жил ингээд явсан. Үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд дээр байдаг мөртлөө хийгддэггүй ажлууд байж л байна. Тэгээд бид дүгнэлт хийж дунд хугацаандаа ямаршуу зорилтууд тавих ёстой юм, яаж төлөвлөлтүүдээ хийх ёстой гэдгийг бодмоор санагдаад байгаа юм.

Орж ирсэн асуудалтай холбогдуулаад ажлын хэсгээс хэд хэдэн асуултууд байна.

2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл дээр бодлогын чиглэлүүдээ заасан байгаа.

“Алсын хараа-2050”-тай нийцүүлээд, хавсралт 3-т нь нийцүүлээд 9 бодлогын чиглэл гарсан байсныг одоо орж ирж байгаа таван жилийн төлөвлөгөөнд 8 болгосон байна л даа.

8 болгож оруулж ирэхдээ –

- “амьдралын чанар, дундаж давхарга” гэдэг заалтыг нь хасаад өөр газар шингээсэн байх шиг байна.
- Улаанбаатар “дагуул хот” гэдэг хэсгийг нь хассан байна.
- Шинээр “үндэсний өрсөлдөх чадвар” буюу өмнө нь “эдийн засаг” гэдэг хэсэг дотор байсныг нь хоёр хуваагаад “эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил”, “өрсөлдөх чадвар” гээд ерөнхийдөө хоёр төстэй юмыг хоёр

салгасан.

- Дээр нь шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун ухаан гээд нэмсэн байна л даа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл би үүнийг яагаад асуугаад байна гэхээр өмнө нь нэг гүйцэтгэл гаргаж байснаа дахиад үнэхээр үүнийг явъя гэж бодож байгаа бол Засгийн газрын хувьд яагаад үүнийгээ өөрчилсөн бэ? Өмнөхөөрөө үргэлжлүүлээд “Алсын хараа-2050” тэр урт хугацааныхаа бодлогодоо нийцүүлээд, тэр бодлогын чиглэлээрээ явж болохгүй яагаад заримыг нь хасаж, нэмсэн юм бэ гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт, өмнө хэлсэн үндэслэлээр энэ урт хугацааны бодлогын бичиг баримт чинь өөрөө хэрэгжүүлэхэд тогтвортой биш учраас, ялангуяа бидний хувьд гадаад орчин дээр зайлшгүй тогтвортой байх шаардлагатай. Гадаад бодлого, аюулгүй байдалтай холбоотой асуудлууд дагаад савлахаар байгаад байна.

Тэгэхээр үүнийг савлуулахгүй байхын тулд 10 жилийн тэр бичиг баримтдаа тусгах чиглэлээр ямар ажлууд хийж байна. Тэнд оруулбал илүү тогтвортой байх бололцоо, боломжууд байгаа юу гэж харж байна.

Г.Тэмүүлэн: С.Бямбацогт сайд асуултад хариулъя.

С.Бямбацогт: Таван жилийн үндсэн чиглэл бараг хэрэггүй юм биш үү. 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр байж байхад үүнтэй бараг л адилхан бодлогын бичиг баримт болох гээд байна гэж.

Тэгээд өнгөрсөн 30 жил ерөнхийдөө ингэж явж ирсэн. 1990-2020 он хүртэл.

Тэгээд ялсан нам болгон өмнөх Засгийн газрын хэрэгжүүлсэн бодлогыг өөрчлөөд, “Бид ялсан учраас бид өөрийнхөө мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.” гээд явдаг.

Тэгэнгүүт төрийн бодлогын залгамж чанар гэдэг юм алга болдог. Урьд нь хийж байсан ажлаа тал нь царцаад, зогсоод, балгас болоод ингээд явж байсан бодлого зогсдог.

Ингээд баахан хөрөнгө зараад тэр нь үр ашиггүй, баахан ажил хийж байгаад үр дүнгүй болдог.

Тэгэхээр төрийн бодлогыг харилцан уялдаатай, залгамж чанартай байлгахын тулд бид 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж.

- Монгол төрийн бодлого тодорхой биш.
- Монгол төрийн бодлого тогтвортой биш.

Ийм болохоор Засгийн газрууд аягүй амархан огцордог. Ерөнхий сайд болсон хүн болгон “би өмнөх Ерөнхий сайдын хийсэн бодлого надад хамаагүй, би өөрийнхөө Ерөнхий сайдын бодлогоо хэрэгжүүлнэ” гээд бодлогыг дандаа өөрчилдөг.

Дөнгөж тэр хоёр давхар байшин бариад эхэлж байсан бол зогсоогоод царцаадаг, эсвэл нураадаг. Хаалга нь баруун тийшээ хардаг байсан бол үгүй, зүүн тийш нь харуулж барь наадхаа гэдэг. Эсвэл урагш нь харуулж барь гэдэг. Энэ л байдлыг засъя. Төрийн бодлого –

- тогтвортой байя,
- залгамж чанартай байя,
- харилцан уялдаатай байя.

Ингэхдээ урт хугацааны бодлогодоо дунд хугацаанд нь уялдуулъя. Дунд хугацаанд богино хугацаатайгаа уялддаг байя гэдэг үүднээс бид Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд –

- 30 жилийн урт хугацааны бодлого,
- 10 жилийн дунд хугацааны 8 зорилтот хөтөлбөр,
- тэгээд таван жилийн үндсэн чиглэл.

Энэ таван жилийн үндсэн чиглэл дээрээ тулгуурлаад “4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”. Үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд “жил жилийн төлөвлөгөө” гэсэн ийм бодлогын бичиг баримтуудтай болсон.

Урьд нь 2020 оноос өмнө 600-аад бодлогын бичиг бичиг баримттай байсан. Улсын Их Хурлаар батлуулдаг. Салбар болгон өөр өөрсдийн –

- эрчим хүчний,
- зам тээврийн,
- төмөр замын,
- авто тээврийн.

Байгаль орчны яам –

- байгаль орчныг хамгаалах,
- байгаль орчныг сэргээх бодлого,
- байгаль орчныг хөгжүүлэх хөтөлбөр,
- ойг хамгаалах хөтөлбөр,
- усыг хамгаалах хөтөлбөр, бодлого.

Тийм үү. Маш олон бодлогын бичиг баримтыг Улсын Их Хурлаар батлуулдаг байсан.

Ингээд 600-аад бодлогын бичиг баримт дунд Засгийн газар, хууль хэрэгжүүлдэг байгууллага төөрдөг. Альныг нь хэрэгжүүлэхээ мэддэггүй.

Их Хурлын гишүүд Их Хурал дуртай бодлогын бичиг баримтын хэрэгжилт нь хаана байна гэхээр маш асуудалтай байсан.

Үүнийг цэгцлээд харилцан уялдаатай –

- энэ л бодлогын бичиг баримтуудыг баталъя,
- үүнийгээ л мөрддөг байя,
- үүнийгээ л “үнэлдэг”, “хэмждэг”, “дүгнэдэг” байя гэдэг хуультай болсон.

Өөр замбараагүй тэр олон 600 бодлого 20-иод бодлогын бичиг баримт дотор багтаж байгаа.

Тэгээд 4 жилийн сонгуулийн циклээр бодлогын бичиг баримтууд уялддаггүй байсан бол бид таван жилийн үндсэн чиглэл орж ирснээрээ одоо уялддаг болж байгаа.

2021-2025 онд “Шинэ сэргэлтийн бодлого” гээд бид таван жилийн үндсэн чиглэлээ баталсан.

2024 оны сонгуульд орсон. Таван жилийн үндсэн чиглэл болон урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт дээр тулгуурлаад намууд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлээд, энэ таван жилийн үлдсэн нэг жилийн бодлогыг оруулаад Их Хуралд сонгуулийнхаа мөрийн хөтөлбөр батлуулаад, үүнийгээ “Хурдтай хөгжлийн төлөө зориг” гээд Ардчилсан нам, Ардын нам, ХҮН намын нийт сонгуулийн амлалтын 80 хувь нь орсон 2024-2028 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөө баталсан.

Одоо бид 2026-2030 оны “Шинэ итгэл-Эрс шинэтгэл” хэмээх нэртэй таван жилийн үндсэн чиглэлээ батлах гэж байгаа.

“Шинэ итгэл, Эрс шинэтгэл” батлаад явахад 2028 онд сонгуульд орно. Сонгуульд орох намууд үүний үлдсэн хугацаанд хэрэгжээгүй бодлогуудыг сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрт тусгана.

Ингээд цаашаа энэ маань ингээд уялдаад явах. Ийм байдлаар сонгуулийн циклээр 4, 4 жилээр хуваагддаг юмыг 5 жил болгосноороо сонгуулийн циклтэй нь уялдуулж... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулж хариулах уу? С.Бямбацогт гишүүн нэмж тодруулж хариулъя.

С.Бямбацогт: Тэгээд ийм байдлаар 4 жилээр тасардаг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанаас хамаараад сонгуулийн циклээр, үүнийг 5, 5 жил болгож, 5 жил болгосноор хоорондоо “уялдаатай байх”, “тасралтгүй байх” бололцоо боломжийг бүрдүүлж өгсөн юм гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Хоёрдугаарт нь, тэр 10 зорилтын хүрээнд 8 үндсэн чиглэл орж ирсэн байгаа. Энэ дээр манай Эдийн засаг, хөгжлийн яамныхан нэмээд хариулъя.

6 номерын микрофон.

Г.Тэмүүлэн: 6 номер. Эдийн засаг, хөгжлийн яам нэмж хариулъя.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яам. Б.Мөнгөнсүх нэмж хариулъя.

Энэ бодлогын хүрээнүүдийг тогтоохдоо –

- ▶ **Нэгдүгээрт**, “Алсын хараа- 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт суурилж, дээрээс доош төлөвлөлтийн зарчмыг баримталсан.
- ▶ **Хоёрдугаарт**, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль дээр байгаа 10 жилийн хугацаатай хэрэгжих дунд хугацааны 8 бодлогын баримт бичиг байна гэсэн бодлогын хүрээнд нийцүүлж 8 бодлогын хүрээгээр тодорхойлсон.

Та асуусан. Нийслэлтэй холбоотой асуудлууд нь тусаагүй юм биш үү гэсэн асуудал ярьсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу энэ таван жилийн үндсэн чиглэл батлагдсаны дараагаар аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг аймаг, нийслэл, хот бүхэн боловсруулаад, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж 1 минут.

Б.Мөнгөнсүх: Хуулийн зохицуулалттай байгаа.

Тэгээд яг энэ өдрүүдэд бүх шатны аймаг, нийслэл, хотын бодлого төлөвлөгчид Засаг даргын Тамгын газрынхан яг энэ бодлогын баримт бичгээ боловсруулж байгаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс ялгаатай нэг гол чухал асуудал нь юу вэ гэхээр энэ үндсэн чиглэлд зөвхөн Засгийн газрын байгууллагуудын үр дүнг тодорхойлоогүй, Монгол Улсын төсвийн 40 ерөнхийлөн захирагчтай хамтарч үр дүнг тодорхойлсон учраас Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагуудын үр дүн, мөн шүүх засаглал дээр ажилладаг байгууллагуудын үр дүн гэх мэтчилэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс илүү өргөн хүрээтэй үр дүнгүүдийг тодорхойлсон байгаа.

Г.Тэмүүлэн: Д.Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Энд их л олон төсөл хөтөлбөрүүд байгаа.

Тэгээд эд нар дээр ер нь төсвөөр таван жилийн хугацаанд улсын төсвөөр хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт яг энэ хөтөлбөрүүд дээр тусгасан үйл ажиллагаанууд зарцуулагдах гээд байгаа. Төр, хувийн хэвшил юм уу, бусад байдлаар шийдэгдэж байгаа нь хэд вэ гэсэн ийм тооцоо гарсан уу, үгүй юу?

Түрүүн яах вэ С.Бямбацогт сайдын юунууд дээр асуудал нь энэ бодлогын бичиг баримтгүйдээ биш, засаг нь өөрөө тогтворгүй байгаа учраас л тэрийгээ дагаад өөрчлөгдөөд байгаа учраас. Үүнийг өөрчлөгдөнгүүт жишээ нь ийм бичиг баримттай болонгуут нөгөө цаад шалтгаан нь байхгүй болоогүй байхад өөрчлөхөө хүрвэл тэгээд л өөрчлөөд л явах байх гэсэн бодолтой байгаад байгаа. Саяын асуултад хариул даа.

Г.Тэмүүлэн: 7 номер асуултад хариулъя.

Б.Төгөлдөр: Эдийн засаг, хөгжлийн яам. Б.Төгөлдөр.

Улсын хөрөнгө оруулалтын таван жилийн үндсэн чиглэлийн хавсралт баримт бичиг болох Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн нийт 87 төсөл тусгагдсан.

Тухайн төслүүд маань 55.2 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

Төслүүдийг санхүүжүүлэх шийдвэрлэгдсэн эх үүсвэрээр нь авч үзвэл –

- “улсын төсөв” болон “орон нутгийн төсөв”-өөр 39 төсөл хэрэгжих гэж байгаа.

— Гадаад зээл, тусламжаар	- 25;
— Шууд хөрөнгө оруулалтаар	- 14;
— Төр, хувийн хэвшлийн түншлэлээр	- 3;
— Засгийн газрын үнэт цаасаар	- 2;
— Холимог эх үүсвэрээр	- 3;
— Бусад эх үүсвэрээр	- 1 гээд.

“Улсын төсөв” болон “орон нутгийн төсөв”-өөр явж байгаа 39 төсөл маань нийт санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийн 45 хувь болж байгаа.

Г.Тэмүүлэн: Д.Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Таван жилийн төлөвлөгөөнүүд маань төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг шиг л харагдаад байгаа л даа.

Төсвөөс баахан юм хийнэ гэсэн. Уг нь бид чинь хувийн хэвшлүүдээ, аж ахуйн нэгжүүдээ дэмжээд бололцоо, боломж, эрх зүйн орчнуудыг бий болгох чиглэл рүүгээ илүү үндсэн чиглэл байхгүйбол баахан ийм юм барина, ийм төсөл хэрэгжүүлнэ гээд.

Өнгөрсөн таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэл харахад ч гэсэн одоо яг түүний гүйцэтгэлийг харвал “хэрэгжсэн” гээд улс, эх орон хөгжсөн юм шиг тийм баахан төслүүд байгаа байхгүй юу. Тэгээд байдал бахь хэвээрээ, ард түмний амьдралд нь наалдсан юм байхгүй. Иймэрхүү л үр дүнтэй. Цаасан дээр л хий баахан ажлууд л яваад байна л даа.

Бодлогын хувьд орчнуудаа сайн болгохгүй бол төр дээр баахан –

- хөрөнгө оруулалт хийнэ,
- өчнөөн их наядын хөрөнгө оруулалтууд хийнэ,
- арга хэмжээ хийнэ гэсэн ийм л байна.

Тэгэхээр би түрүүн хэлсэн санаагаа давтаж хэлэхэд... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Саналаа гүйцээгээд хэлье.

Д.Энхтүвшин: Тэгэхээр ядаж хэдүүлээ өнгөрсөн таван жилийнхээ гүйцэтгэлээ нэг дүгнээд ярья. Тэгэхгүй бол одоо ингээд нэг ийм “бушуу туулай борвиндоо баастай” гэдэг шиг гүйсэн, харайсан л хүмүүс байх юм. Хойноос цаг хугацаанд баригдсан л гэнэ. Тэгээд цаг хугацаа байгаа гээд. Заримынх нь цаг хугацааг гүйцэлдүүлж хэдүүлээ Их Хурал дээрээ ярихгүй байж дахиад л дараагийнх нь юмыг ярьж байна.

Тэгээд л энэ нь ингээд л ийм гүйсэн, харайсан байдалтай л байгаа юм. Хэдүүлээ зогсож, яг энэ бид нарын хүсээд байгаа юм чинь ард түмний амьдралд яг наалдаж байгаа юм уу, үгүй юм уу. Энэ юм чинь болж байгаа юм уу, болохгүй юм уу, яаж сайжруулах юм гэж явахгүй бол.

Би яг үнэндээ хэлэхэд энэ өнгөрсөн таван жилийн гүйцэтгэлүүдийг харахад энэ дээр цэнгэлийн манлайд хүрсэн юм шиг байгаа байхгүй юу. Гэхдээ бодит байдал дээр тийм биш. Тэгээд эргэж харъя л гэж бодоод байгаа юм.

Тэгээд тэрний дараа энэ асуудлаа ярилцъя гэсэн ийм бодолтой байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ерөнхийдөө санал хэллээ гэж ойлголоо. Тийм ээ. Г.Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Асуулт асуугаад хариулах хүн байгаа юм уу? Байхгүй байгаа юм биш үү дээ. Сайд нар бүгд гараад явлаа шүү дээ.

Н.Учрал сайд чинь намын дарга болоод алга боллоо. Байхгүй. С.Бямбацогт сайд чинь түрүүн хариулах гэж байна гээд гараад явах юм. Ямар учиртай юм. Зарчмын юм асуух гээд байгаа юм.

- Монгол Улс урт хугацааны төлөвлөгөө,

- дунд хугацаа төлөвлөгөө,
- богино хугацааны төлөвлөгөөтэй.

Үүнтэй холбоотойгоор хуучин сайд нарын яриад байгаа тэр олон 600 гаруй хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг нийлүүлээд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг гаргаж цэгцэлсэн гээд байгаа юм.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5 дээр 8 төрлийн хөтөлбөрийг боловсруулж батлуулах ёстой гээд байгаа юм.

Тэгээд үүнийгээ батлуулаагүй байж алгасаад таван жилийнхийг оруулж ирээд батлуулаад, хоёр дахь таван жилийнхээ төлөвлөгөөг батлуулах гээд явж байна л даа.

Тэгээд хууль байхад хуулиа хэрэгжүүлэхгүй юм бол одоо тэгээд яах юм цаашаа. Тэгээд ер нь цаашдаа хурал хуй, энэ Байнгын хорооны хурал, парламентын засаглал чинь өөрөө ганхаад байна гэдгийг Их Хурлын гишүүд ойлгож байгаа юм уу, үгүй юм уу.

Өчигдөр гэхэд Монгол Ардын нам, ганцхан нам хурлаа хийхийн төлөө парламент тасралтгүй үйл ажиллагаа явуулах ёстой. Өчигдөр баахан Байнгын хороодын хурал төлөвлөгдсөн байсан. Нэг цагийн дотор бүгдийг нь хойшлуулаад гацаагаад, маргааш, нөгөөдөр лүү нь шилжүүлдэг ийм байж болох юм уу. Энэ Монгол төр чинь ямар ч тогтворгүй боллоо шүү дээ.

Парламентын засаглал гэж байгаа юм уу. Их Хурлын гишүүдээ тоодоггүй. Үг хэлэхээр үгийг нь авдаггүй.

Эдийн засгийн байнгын хороо. Өнөөдрөөс Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр хэлэлцэнэ. Энэ Байнгын хорооноос өгч байгаа тогтоол, тушаал, шийдвэрүүд, Их Хурлаас гарсан тогтоолуудын хэрэгжилт тун тааруу байгаа шүү дээ. Гучин хэдэн хувьтай орж ирэх гэж байна. Тайланг нь сонсоход.

Урьд нь Эдийн засгийн байнгын хороон дээр 48 хувьтай байгаа.

Тэгээд энэ засаглал чинь ер нь юу болж хувираад байгаа юм бэ? Үүнийгээ бодох ёстой байх аа, Их Хурлын гишүүд ээ.

Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөө дэмжихгүй байгаа. Их гоё гоё уран цэцэн юм яриад байгаа мөртлөө. 1 минутаа нэмээд авъя.

Тэр стратеги төлөвлөгөө буюу урт хугацааныхаа төлөвлөгөөтэй ерөөсөө нийлэхгүй, зохицохгүй, үр дүн нь хоёр өөр зөрж байгаа. Тэрийг нь шалгуур үзүүлэлттэй нь тоотой нь хэлсэн би. Чуулган дээрээс. Байнгын хороон дээр ч гэсэн хэлсэн.

Тэгээд одоо яг энэ цаг хугацаанд энэ гүйцэтгэх засаглал нь засаглал шиг ажлаа хийгээд, эхлээд энэ тайлангаа сонсмоор байна.

2021-2025 оны хооронд 150 төсөл, хөтөлбөр хэрэгжээд, төсвийн 117 их наяд төгрөгийг үрчхээд 50-хан хувьтай байгаа шүү дээ.

Тэгээд 50 хувьтай Монгол Улсыг хөгжүүлж байхад бид энэ дээр ямар нэгэн дүгнэлт боловсруулж, хуулийн дагуу –

- Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу,
- Дэгийн тухай хуулийн дагуу,
- Хяналт шалгалтын тухай хуулийн дагуу,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн дагуу –

- Байнгын хороодоор орж хэлэлцэж, Их Хурал дээрээс тогтоол гаргаж, чиглэл өгөх ёстой.

Энэ чиглэлийн дагуу Засгийн газар дараагийн таван жилийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулаад орж ирэх ёстой. Тэрийгээ хийхгүй шууд ингэж дайрч байна шүү дээ.

Тэгээд ганц юм хэлдэг болсон. Хуулийн хугацаа гэсэн. Хугацаа нь тулсан болохоор гээд шахдаг, үгийг нь сонсдоггүй. Тэгээд ийм байдал руу л орлоо шүү дээ.

Тэгээд би энэ яамны мэргэжилтнүүдээс асуух юм байхгүй. Бүтэн жил 6 сар асуулаа. Хөөрхий амьтад хариултыг нь ч мэдэж байгаа.

Тэгээд энэ хуулиа хэрэгжүүлэхгүй байгаа дарга нарыг чинь яах ёстой юм? Парламентын гүйцэтгэх засаглалтайгаа хариуцлагаа тооцож чадах юм уу, чадахгүй юм уу?

Хариуцлага тооцно гээд хална, солино гээд байгаа юм биш шүү дээ. Ажлаа сайжруулъя аа, юмаа ярья аа, хуулиа мөрдье л гэж байгаа шүү дээ.

Тэгээд сайд нар байхгүй юман дээр. Одоо асуух асуулт дүүрэн л байна л даа. Тэгээд гараад явчих юм. Чуулган дээрээс би асуусан болохоор энэ Г.Очирбатын цаг нь боллоо гээд гарч байгаа юм уу, яаж байгаа юм. Бүр гайхчихлаа. Харин. Байнгын хорооны дарга аа, нээрээ. Танд очоод түрүүн юм хэлээд л гараад явчих юм. Ингэж болохгүй шүү дээ. Ядаж ганцхан гишүүн үлдсэн байна. Асуултад нь хариулаад гар л даа. Асуух юм зөндөө байна шүү дээ.

Энэ урт хугацааныхаа төлөвлөлттэй нийцэхгүй дунд хугацаа. Ингээд шалгуур үзүүлэлттэй нь гаргаад ирсэн тоо, хүний хөгжлийн индексүүд хоорондоо зөрсөн. Тэгээд 2030 он хүртэл төлөвлөгөө нь орж ирэхдээ энэ алсын хараатайгаа нийцдэггүй ийм байдалтай энэ улс хөгжих юм уу?

Д.Энхтүвшин гишүүн ч гэсэн хэлээд байгаа шүү дээ. Чуулган дээр ч гэсэн хэлсэн шүү дээ. Эхлээд тайлангаа хэлэлцье. 50 хувьтай ажлаа хийчхээд, цаашаа ямар нэгэн чиглэл, үүрэг даалгавар авахгүйгээр дараагийн төлөвлөгөөг оруулж ирээд тэр нь урт хугацааныхаа төлөвлөгөөтэйгөө зөрсөн.

Тэгээд энэ байдлаар цаашаа удирдана гэвэл Монгол Ардын намын эрхэм гишүүд, дарга нар манийг бодвол олон жил суусан туршлагатай болсон хүмүүс. Тэгээд энэ дээр анхаараад хуулиа хэрэгжүүлмээр байна.

Тэгээд сайд нараа оруулж ирмээр байна. Байнгын хорооны дарга аа.

Г.Тэмүүлэн: Г.Очирбат гишүүн зарчмын л саналыг хэлж байна.

Яах вэ, сая бусад Байнгын хороодын хэлэлцүүлгүүдийг ч гэсэн харахад ер нь үр дүнгүй хэлэлцүүлгүүд их болж байна. Сайд нар нь оролцоо багатай байна. Хүрэлцээ байхгүй болсон. Ихэнх сайд нь гадагшаа, дотогшоо томилолтоор явсан. Ганцхан Хэрэг эрхлэхийн сайд нь Байнгын хороо дамнаж асуултуудад хариулж байгаа. Цаг хугацаа нь шахагдсан ийм хэлэлцүүлгүүд болж байна гэдэгтэй би хувь хүнийхээ үүднээс бүрэн дүүрэн санал нийлж байна.

Энэ дээр бидний хувьд үндсэн чиглэл болоод таван жилийн төлөвлөгөөтэй холбоотойгоор цаг хугацаа, хэлэлцүүлэг, энэ хоорондын асуудлууд дээр ч гэсэн анхаарах зүйлүүд байна.

Засгийн газар заавал ч үгүй 10 сарын 01-нээс өмнө өргөн барьдаг. Тэрийг нь Улсын Их Хурал 12 сарын 01-нээр баталдаг гэдэг сарын дотор нэг ийм цаг хугацаанд шахагддаг үр дүнгүй хэлэлцүүлгүүд болдог үндсэн суурь шалтгаан маань хууль эрх зорчин зохицуулалт талаасаа байна гэж хараад байгаа. Үүнийг ч гэсэн зайлшгүй өөрчлөх шаардлага байна гэж харж байгаа.

Би сая асуудал хариуцсан сайдыг хэлэлцүүлгийг дуусгаад яваач ээ гэсэн. 3 цагаас Засгийн газар хоорондын хэлэлцээртэй байгаа. Энэ дээр хүлцэл өчиж байна гээд явсан. Аль болох л байлгах гэж үзлээ.

Бусад энд байгаа сайд нараас П.Наранбаяр сайд, Ж.Энхбаяр сайд нараас нэмж хариулах, тайлбар өгөх зүйлүүд байгаа юу? Яалт ч үгүй л юу гэдэг юм анхны хэлэлцүүлгүүдээ энэ долоо хоногтоо бид хийгээд, дараа долоо хоногт эцсийн болоод, гуравдугаар хэлэлцүүлгүүд явах, гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлгүүд явах л хуулийн хугацаанд л шахагдаад байдаг. Тэгээд өнөөдөр хойшлуулна гэхээр маргааш, нөгөөдөр дөрөв дэх, тав дахийн чуулган.

Тэгэхээр үнэн. Г.Очирбат гишүүнтэй би санал нийлж байна. Үүнийг уг нь ийм чухал асуудлыг, бодлогын асуудлуудыг бид зүгээр хоёр долоо хоногийн дотор шахагдаад хэлэлцүүлсэн болоод, үр дүнгүй яваад байдаг зүйл харамсалтай байна.

Тэгэхээр бид үүнийг сууриар нь яахын тулд Улсын Их Хурал ч гэсэн өөрсдөө төлөвлөгөө батлах хуулиудынхаа цаг хугацаа, дэс дараалал, мөн таны хэлсэн

хуулийн хэрэгжилтийг дүгнэх энэ асуудлуудыг ч гэсэн дотроо цаг хугацааны хувьд бодитоор нь дүгнэх боломж бололцоог нь гаргаж өгөх зайлшгүй шаардлага байна л гэж харж байгаа. Хүлцэл өчье. Г.Очирбат гишүүнээс.

Тэгээд дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр тодорхой хэмжээнд бид хариуцлагатай хандах зайлшгүй шаардлага байна гэдгийг хэлэх байна. Сая цаг хугацааны хувьд ч гэсэн, зохион байгуулалтын хувьд ч гэсэн яалт ч үгүй ингээд шахагдаад ингээд явсныг ойлгоно биз гэдгийг хэлэх байна.

Засгийн газрын гишүүд ч гэсэн энэ асуудал дээр анхаарч ажиллаарай. Бусад сайд нартаа шаардлага тавиарай. Энэ удаагийнх биш, бусад Байнгын хороод энэ дөрөв дэх, тав дахь болон дараа долоо хоногийн хэлэлцүүлгүүд дээр бүрэн дүүрэн хариултуудыг өгөх, асуултуудад хариулах асуудлууд дээр анхаарч ажиллах зайлшгүй шаардлага зүйл байна гэдгийг хэлэх байна.

Би нэг зүйлийг уг нь тодруулж асууя л гэж байсан. Эдийн засаг, хөгжлийн яамныхан байгаа учраас, асуудал хариуцсан яамныхан учраас энэ үндсэн чиглэлтэй холбогдуулаад мэргэжлийн хүмүүсээс нь, яг Эдийн засаг, хөгжлийн яамныхан юу гэж бодож байгаа юм. Үүнийг асуух гэсэн юм.

Тэгээд энэ өөрөө юу юм бэ гэхээр бидний хувьд энэ үндсэн чиглэлд тусгагдаагүй нэг асуудал байна. Үндсэн чиглэлд тусгагдаагүй асуудал байна. Энэ улс орны хөгжлийн асуудлыг ярья гэвэл, цаашдаа бид тогтвортой хөгжлийг ярья гэвэл хүний хөгжлийг ярих ёстой болоод байгаа юм. “Хүний хөгжил”.

Тэгээд тэр дотроо хүнийхээ аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой, ирээдүйнхээ хүний хөгжлийг дэмжихтэй холбоотойгоор удмын сангийн аюулгүй байдлын бодлогын асуудал байгаа.

Улсын Их Хурлаас 2022 оны 01 дүгээр сард батлагдсан тогтоол байгаа. Засгийн газраас аваад үзэхээр энэ тогтоолын хэрэгжилт нэгдүгээрт хангалтгүй байгаа юм.

Хоёрт, энэ тогтоолын заалт нь хэрэгжээгүй боловч энэ асуудлыг ирэх таван жилийн үндсэн чиглэлд тусгахгүйгээр орж ирсэн байна.

Тэгэхээр би бодлого барьж байгаа Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс ер нь энэ хүнийхээ хөгжлийн асуудлыг ер нь юу гэж бодож байгаа юм бэ. Бид цаашид хүний хөгжил, дээрээс нь удмын сангийн бодлого. Ингэж байж цаашдаа тогтвортой хөгжлийн өөрөө бодлого нь гарч ирэх гээд байгаа юм.

Эрүүл боловсролтой, бүтээлч иргэдтэй болох ч өөрөө бид нарын номер нэг зорилго болоод байдаг. Эдийн засгийнхаа бүтээмжийг өсгөх нь өөрөө бид бүхний зорилго болоод байдаг. Хүнийхээ эрүүл мэнд болоод, нийгмийнхээ асуудлыг нь хамгаалах нь, энэ чиглэлийн зардлуудыгаа бууруулах нь өөрөө нэг талдаа нийгэм болоод эрүүл мэндийнхээ чиглэлээр хүнээ дэмжиж байж ирээдүйд магадгүй учирч болох тэр эрсдэлүүдээс хамгаалах, тэр чиглэлээр төрөөс гаргаж байгаа зардал ч

яваандаа буурах боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа. Нөгөө талдаа бид бүхний хувьд шинжлэх ухаанд суурилсан бодлоготой болох зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Тэгэхээр би яриад байгаа асуудал энэ “удмын сангийн аюулгүй байдал”, “хүний хөгжлийг дэмжих” тогтоолтой холбоотой асуудал бол бид энэ “генетик судалгааг хөгжүүлэх” гэдэг асуудлыг голчилж тавьж өгсөн.

Энэ чиглэлээр бид –

- тодорхой бодлоготой байя,
- төрийн бүтэц, тогтолцоотой байя,

-бүр болж өгвөл олон улсын стандартын генетикийн судалгааг хөгжүүлэх лабораторитой болъё гэдэг асуудлыг яриад байгаа юм.

► Генетикийн судалгааны асуудал зөвхөн хүний эрүүл мэндтэй холбоотой асуудал биш –

- бусад бүх салбарын хөгжилтэй холбоотой асуудал болоод байгаа юм,
- шинжлэх ухааны салбарын хөгжилтэй холбоотой асуудал болоод байгаа юм.

Энэ чиглэлээр **“үндэсний хөтөлбөр”** болоод **“хуультай”** болох асуудлыг зайлшгүй хийх шаардлагатай байна. Улсынхаа хөгжлийг, хүнийхээ хөгжлийг бид илүү шинжлэх ухаанчаар хэрэгжүүлэх шаардлага байна гэдэг зүйлийг хөндөж тавиад байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал өөрөө энэ үндсэн чиглэл дээр тусгагдаагүйгээр орж ирлээ.

Хоёрт, энэ чиглэлээр Улсын Их Хурлаас гаргасан тогтоол болоод хууль тогтоомжийн хэрэгжилт өөрөө хэрэгжээгүй явж ирсэн байна. Засгийн газраас энэнтэй холбоотойгоор асуулга тавиад, холбогдох мэдээллүүдийг авахаар 9 сараас хандсан. Одоогоор бүрэн дүүрэн гүйцэт мэдээлэл, тайлбар, тайлангууд ирээгүй байна гэдэг асуудлыг тавих гээд байгаа юм.

Тэгэхээр ер нь Та бүхний хувьд энэ –

- “хүний хөгжил”,
- “генетикийн оношилгоо”,
- “генетикийн судалгаа”-тай –

-холбоотой шинжлэх ухааны салбарт шинжлэх ухаанчаар илүү хүнийхээ хөгжилд хандах асуудлууд дээр ер нь яг юу гэж үзэж байгаа юм бэ? Энэ асуудлыг асуух гэсэн юм.

6 номер. Эдийн засаг, хөгжлийн яам.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яам. Б.Мөнгөнсүх. Асуултад хариулъя.

Ттаван жилийн үндсэн чиглэл дээр нийтдээ 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтарч ажилласан байгаа. Хуулийн дагуу дээрээс доош төлөвлөлт буюу дээд эрэмбийн бодлогын баримт бичгээс үр дүнгүүдийг буулгаж ирэх, мөн түүнчлэн доороос дээш төлөвлөлт буюу төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирж байгаа санал дээр нөхцөл байдлын дүн шинжилгээг үндэслэж бодлогын үр дүнгүүдийг тодорхойлсон байгаа.

Ингээд 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай бид бүхэн дээд тал нь 7 удаа, доод тал нь 3 удаагийн уулзалтууд хийж, үр дүнгүүдийг нэгтгэсэн байгаа.

Тэгээд энэ хүрээнд санал тусгагдаж ирээгүй.

Тийм учраас юу вэ гэхээр хэлэлцэх явцад ажлын хэсэг дээр энэ саналыг нэмж оруулах боломжтой гэж үзэж байна.

Г.Тэмүүлэн: Индэр дээрээс нэмж хариулъя.

Б.Ганбат: Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат байна.

Г.Тэмүүлэн гишүүний асуултын хоёр дахь хэсэг “хүний удмын сан”, “генетик судалгаа”, лабораторитой холбоотой хэсэг дээр хариулт өгье.

Ер нь эрүүл мэндийн асуудал цогцоороо орсон байгаа. Ялангуяа тулгамдаж байгаа асуудал, зонхилох өвчнүүд, түүнийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, эсрэгээр бүх үзүүлэлтүүд Тогтвортой хөгжлийн зорилтынхоо индикатортайгаа уялдуулаад бид бүгдийг нь тодорхой оруулсан.

Удмын сангийн хувьд Эрүүл мэндийн яамны байр суурийг мэдэхгүй байна. Бид нарт ийм тодорхой санал ирээгүй.

Зүгээр миний мэргэжил өөрөө анагаахын биофизикч учраас мэргэжлийнхээ үүднээс хариулах гээд үзье гэж бодож байна.

Дунд хугацааны үндсэн чиглэл өөрөө ерөөсөө 2030 он гэхэд бид тухайн салбар чиглэлээр ямар түвшинд хүрэх вэ, үүнийгээ юугаар хэмжих вэ гэдгийг л бид тодорхойлж байгаа.

Өнөөдөр Хүн судлалын хүрээлэн гэж байгаа. Байгуулагдсан байдаг. Судалгааны яг энэ чиглэлийн генетик, хүний антропологи, генетикийн судалгааны төв байдаг. Төрийн өмчит хүрээлэн байна.

Энэ дээр ямар ямар судалгаа хийгдэж байна, юуг анхаарах вэ, удамшилтай холбоотой өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ажиллагаа хийж байгаа талаар мэдээлэл алга байна.

Зүгээр мэргэжлийн хүний хувьд хэлэхэд удамшлын өвчнүүд урт хугацаанд явагддаг мутацитай холбоотой байдаг учраас таван жилийн дотор яг тодорхой ахиц гарах төвөгтэй гэж үзэж байна. Энэ бол урт хугацаанд явагддаг процесс.

Тэгэхдээ мэдээж энэ анхаарах ёстой асуудлын нэг мөн. Тэгэхдээ энэ саналыг цаашдаа ажлын хэсэг дээр ярилцаад тусгаж болох байх гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Манай Эдийн засаг, хөгжлийн яамныхан анхаарах ёстой зүйл нь ийм л зүйл болоод байгаа шүү.

Ирээдүйн хөгжлийг ярьж гэвэл –

- Хүнийхээ хөгжлийг ярих ёстой болоод байна.
- Хүнийхээ хөгжил дээр илүү хариуцлагатай хандах ёстой болоод байна.
- Хүн амаа хамгаалах хэрэгтэй болоод байна.
- Хүнсний аюулгүй байдлыг нь хангах чиглэлээр дэд бүтэц, тогтолцоо нь хэрэгтэй болоод байна.
- Эрүүл, аюулгүй орчинд нь тухайн хүн өсөж торних, амьдрах нөхцөл, орчныг нь бий болгох хэрэгтэй болоод байна.

Тэгэхээр үүний гол асуудал нь –

- хүний хөгжлийн бодлогын асуудал,
- удмын сангийн аюулгүй байдлын асуудал байгаа.

Улсын Их Хурал яг одоогоос 3 жилийн өмнө, бүр он гарах юм бол 4 жилийн өмнө яг энэ чиглэлээр бодлого нь гарсан. Засгийн газраас энэ бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ямар ч алхам хийгдээгүй явж ирсэн байна. Хэрэгжилтийнх нь түвшин нь бараг “0” түвшинд байна гэдэг асуудал байгаа.

Ирэх үндсэн чиглэл дээр энэ талаар тусгасан бодлого гэдэг зүйл байхгүй байна.

Тэгэхээр бид ийм гол чухал асуудал дээр, ирээдүйн үеийнхээ чанарын баталгаатай холбоотой асуудлууд дээр, хүнээ хамгаалах асуудлууд дээр ийм хайхрамжгүй хандаж боломгүй байна.

Тэгэхээр би Та бүхэнд чиглэл болгох гэж байгаа зүйл бол энэ долоо хоногтоо багтаад яг энэ удмын сангийн аюулгүй байдалтай холбоотой, хүний хөгжилтэй

холбоотойгоор энэ асуудал дээр тодорхой тусгаж, нэмж оруулах, төсөл, хөтөлбөрийн –

- зорилго,
- арга хэмжээ,
- хүрэх үр дүн,
- шалгуур үзүүлэлтүүдийг нь –

-нарийвчлан томъёолоод Улсын Их Хуралд, манай Байнгын хороонд, надад хүргүүлж ирүүлэх хэрэгтэй байна.

Улсын Их Хурал дээрээс үндсэн чиглэлийг батлахтай холбоотойгоор ажлын хэсэг гаргасан. Ажлын хэсэг энэ долоо хоногтоо ажиллаад, болж өгвөл ирэх долоо хоногийн эхээр ажиллаад тодорхой хэмжээнд хэдий богино хугацаанд ч гэсэн Улсын Их Хурал энэ үндсэн чиглэлийг илүү хүнийхээ хөгжилд хэрэгтэй, хүртээмжтэй байдлаар, бодлого нь зөв, оновчтой байхаар томъёолоод өөрчлөлтүүдийг хийнэ.

Тэгэхээр Та бүхэн зөвхөн саяын миний хэлсэн чиглэлээр биш бусад асуудлууд дээр ч гэсэн Та бүхнийг төлөвлөхдөө энэ бодлогын баримт бичгийг боловсруулахдаа алдсан, оносон, дутуу орхигдуулсан зүйлүүд юу байна. Үүнийгээ бүгдийг нь нэг бүрчлэн шүүж үзээд танилцуулаарай. Хэлэлцүүлгийн явцад сайжруулаад явъя.

Энэ зөвхөн Засгийн газрын бодлого биш, Улсын Их Хурлын бодлого биш, энэ өөрөө Монгол төрийн бодлого ирэх таван жилд бид бүхэн хөгжлөө яаж харах вэ гэдэг үндсэн чиглэл байгаа гэдгийг би чиглэл болгож хэлэх байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос үндсэн чиглэлийн тогтоолын төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд одоогоор байхгүй байгаа.

Аюулгүй байдлын байнгын хороон дээр гаргаагүй ч гэсэн дараа дараагийн яг бүх саналууд эцэслэгдэх Эдийн засгийн байнгын хорооны хурлыг бид ирэх долоо хоногийн хоёр дахь өдрийн үдээс хойш хийхээр төлөвлөж байгаа.

Тэгэхээр Та бүхэн цаг хугацаа тулсан гээд энэ долоо хоногт саналаа гаргаж амжаагүй бол ирэх долоо хоногийн хоёр дахь өдрийн үдээс хойш хуралдах Эдийн засгийн байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналаа бэлтгээд гаргаж өгч болно шүү.

Мөн дээрээс нь ажлын хэсэг Улсын Их Хурлаас томилогдсон байгаа. Бүх намуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэг энэ долоо хоног болон ирэх долоо хоногийн эхэнд ажиллаад хоёр дахь өдрийн үдээс хойших Байнгын хорооны хуралдаанд саналаа хүргүүлнэ.

Тэгэхээр Та бүхэн ажлын хэсэгт өөрсдийн тодорхой саналуудаа хүргүүлж болно. Энэ дотор тодорхой зарчмын зөрүүтэй саналууд, бодлогын чиглэлээр өөрчлөлт хийх асуудлууд байвал миний бие болоод манай Байнгын хороонд гишүүд хүргүүлээрэй гэдгийг хэлэх байна.

Ингээд ирэх долоо хоногийн Эдийн засгийн байнгын хорооны хурлын даргаар үндсэн дараа дараагийн шатын хэлэлцүүлгүүд чуулганаар дөрөв дэх, тав дахь өдрөөс хэлэлцээд явна.

Тэгэхээр бид бүхэнд энэ үндсэн чиглэлийг илүү чамбайруулах долоо хоногийн хугацаа байна гэдгийг Та бүхэндээ мэдээлэл болгож хэлэх байна.

Ингээд хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Манай Байнгын хорооноос хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх болно.

Эдийн засгийн байнгын хорооны төлөөлөл болж хүргүүлэх гишүүн Д.Энхтүвшин гишүүн байгаа юу. Н.Батсүмбэрэл гишүүн танилцуулахаар тогтоё.

Дараагийн асуудал.

**Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн
биелэлтийн тайлан**

Хоёр дахь асуудал. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

Биелэлтийн тайланг Засгийн газраас танилцуулна. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлангийн танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хийх ёстой.

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт сайд танилцуулах байсан.

Сайд тодорхой шалтгааны улмаас байхгүй байна. Тэгэхээр асуудлыг хойшлуулах саналыг гаргаж байна.

Байнгын хороон дээр холбогдох асуудал эрхэлсэн сайд л асуудлаа танилцуулах үүрэгтэй.

Засгийн газрын төлөөлөл ажлын хэсгийнхэн, сайдад асуудлыг уламжлаарай. Тэгэхээр энэ бол заавал ч үгүй чухал асуудал. Дээрээс нь төрийн эрх барих дээд байгууллага буюу Улсын Их Хурал нь өөрийнхөө хуулийн хэрэгжилтийн тайланг авч

байгаа учраас энэ асуудал дээр бид бүрэн бүрэлдэхүүнээрээ холбогдох сайд нар нь өөрөө хариуцлагатай оролцож, асуудлуудад хариулж хандах ёстой гэж үзэж байгаа.

Энэ үүднээс асуудлыг дараагийн долоо хоног хүртэл хойшлуулж байна. /алх цохив/

Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 15 цаг 01 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД